

XIV-XVII ЗУУНЫ МОНГОЛЫН ГАДААД ХАРИЛЦАА

МУИС, ОУХС-ийн профессор,
доктор (Ph.D) Хэрээд Ж.Баясах

1368 онд Хятадад Монголын Юань гүрний ноёрхол унаж монголчууд эх нутагтаа буцаж ирсэнээр Монголын түүхийн өөр нэгэн үе эхэлсэн бөгөөд эл үеийг (XIV-XVII зуун) Монголын феодалын бутралын үе буюу Умарт Юань улсын үе ч гэдэг. Өгүүлэн буй үед Монгол орон улс төрийн талаар тогтворгүй, эдийн засгийн талаар сул дорой улс болсон байв. Урьдын их гүрний сүр хүч үгүй болж, газар нутгийн хувь бага, хүн ам цөөн, гадаад ертөнцөөс таслагдсан байв. Эзэн Чингисийн үед байгуулагдсан хувь улсуудаас зөвхөн Алтан Орд /1240-1280/ Орос орныг эзлэнэж байсан агаад эх нутагтайгаа төдийлөн холбоогүй байлаа. Тухайн үеийн Монгол зөвхөн шууд хиллэж байсан Хятадын Мин /1368-1644/ улстай идэвхитэй гадаад улс төрийн харилцаатай байв.

Ер нь Монгол-Хятадын харилцаа эрт цагаас эл үе хүртэл "улс төрийн харилцаа" байсан бөгөөд Цагаан хэрмээр хил хязгаар нь тогтсон байв. Хятад улс Зүүн Хойт Азийн бусад орнуудтай, тухайлбал Япон, Солонгостой байгуулсан харилцаа бол ихэвчлэн "соёлын харилцаа" байсан. Өөрөөр хэлбэл тэдгээр оронд Хятадын соёл дэлгэрч бичиг үсэг, шашин шүтлэг, оюун санааны үзэл бодол хийгээд амьдралын хэв маяг ч дэлгэрсэн, дэлгэрүүлэхэд хүргэсэн харилцаа байсан юм.

Монголын язгууртнууд Юань улс мөхсөнөөр төрөлх нутагтаа буцаж ирсэнээр Монгол-Хятадын харилцаанд үндсэн өөрчлөлт гарч улмаар тэрхүү харилцаа бие даасан хоёр орны харилцааны үндсэн дээр үргэлжлэн хөгжих болжээ.¹

Өгүүлэн буй үед Монгол-Хятадын харилцааг тодорхойлж, гадаад бодлогыг заларч нь монголын хаад, ноёд байсан бөгөөд эдгээрийн дотроос Аюушидар /1370-1378/, Эсэн тайш /1440-1455/, Батмөнх /1460-1543/, Алтан хан /1532-1582/, Лигдэн хаан /1604-1634/ нар аргагүй тодорсон юм.

Дээр өгүүлсэн ихэс дээдэс Хятадын талаар ямар бодлого явуулж байсныг он дарааллын байдлаар өгүүлсүгэй.

1370 онд Монголын их хааны орыг Юань сүүлчийн эзэн хаан Тогоонтөмөрийн хүү Аюушидар залгаж Билэгт хаан хэмээн

өргөмжлөгдөж, Монголын улс төрийн төв дахин Хархорумд төвлөрөх болжээ.

Тэр Хархорумд цэрэг эрсээ бүртгэж Хятадыг эзлэн авах эрх мэдлээ сэргээн бэхжүүлэхийг оролджээ. Монголын нэлээд цэргийн хүч Хятадын нутаг дэвсгэр дээр байсан нь энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлж байв.² Мин улсын эхэн үед монголчууд Ганьсу, Шэньси, Шаньси, Шаньдун, Хунань, Хубэй, Хэнань, Хэбэй, Цзянсу, Аньхуй зэрэг Хятадын мужуудад олноор сууж байсан агаад³ нийслэл Бээжин хотын хэрмэн хотод оршин суугч 30 мянган хүний 10 гаруй мянган нь гэхэд монголчууд байсан байна.⁴ Хятадад үлдсэн монголчуудын талаар Манжийн ордон заар татах бодлого явуулж, цалин пүнлүү өгч, заримуудад нь соёрхлын газар хишиг болгон олгож, төрийн албанд зүтгэхийг хүртэл зөвшөөрсөн болно. Шинэ тулгар тогтсон Мин улс эхэн үедээ эдийн засаг, улс төрийн хувьд хараахан батжиж чадаагүй учир монголчуудтай харилцаагаа цэрэг дайны аргаар бус улс төрийн аргаар зохицуулах бодлого явуулж байв. Мин улсын хаан Чжу Юаньчжанаас Аюушидар хаанд хэд хэдэн удаа найрамдалт харилцаа тогтоох зорилгоор элч илгээсэн авч Монголын тал хүлээн аваагүйн дээр Хятадад аюул занал учруулсан хэвээр байв. Энэхүү нөхцөлд Мингийн ордон монголчуудыг цэргийн хүчээр номхотгох бодлогод шилжин 1372 онд 3-н чиглэлээр Монгол руу үлэмж хэмжээний цэрэг хөдөлгөжээ.

Мингийн цэргийн төв хэсгийг Сюй Дэ жанжнаар удирдуулж Өвөр Монголд нэвтрүүлсэн авч монголын жанжин Хөх Төмөрийн цэрэгт цохигдон 10 мянган хүнээ алдаж хамгаалалтанд орсон. Ли Бэньчжунаар удирдуулсан зүүн жигүүрийн цэрэг давшсаар Хэрлэн гол хүрч, тэндээсээ баруун хойшоо эргэж Туул, Орхон голын сав газар хүрсэн нь ч амжилт олоогүй бөгөөд их тооны хохирол амсчээ. Фан Шэнээр удирдуулсан баруун жигүүрийн цэрэг Ланьчжоу, Цзинчжоу зэрэг газраас хөдөлж тулалдааны явцад Ицзинай муж руу орж иржээ. Гэвч 1372 оны эцсээр Хятад цэргийн бүх анги ар тийшээ ухарсан байна. Ийнхүү "барын зулзаалыг бага дээр нь" дарах гэсэн Мингийн ордны санаархал бүтэлгүй болов. Дараа жил нь монголчууд Шаньси, Хүйчжоу, Ляонин, Хэбэйг ойролцоо газраар довтолж Синхэ, Фунин, Суйжун зэрэг чухал стратегийн байрлалтай газрыг эзэлсэн ажээ. 1374 онд Мин нар Синхэ болон Гаочжоу хэмээх газруудаа чөлөөлж авсан хэдий ч Монголруу дахин довтлох

сөхөөгүй байв. Харин ч Аюуширдар хааны хүү Майдарбалыг барианаас сулгаж буцан монголчуудтай найрамдах хүсэлтээ илэрхийлжээ. Ингээд Мин Монголтой 1378 он хүртэл дайны ажиллагаагаа зогсоон найрамджээ.

Мин улсын эзэн хаан Чжу Юаньчжан Аюуширдар хаан нас барахад эмгэнэл илэрхийлж дараахь зарлиг гаргажээ. Зарлигт: "Эрхэмсэг ван говь газраа захирах, миний бие Дундад улсаа захирах байв. Эрхэмсэг ван олон түшмэдүүдэд тулштай бодлого баримталсаар хил хязгаарт түлшүүр үймээн үгүй байлаа. Өнөө эрхэм вантныг говь нутагт оршуулах гэж буйг сонсоод ихэд гашуудаж, улмаар тусгайлан элч илгээж эмгэнэл илэрхийлэн нас барсны хойноос мөргөл үйлдэв" гэжээ. Ийнхүү Монголын хаан Аюуширдар мөн хятадын хаан тус тусын харьяат газар орноо эзэгнэн байх эрх мэдлээ харилцан хүлээн зөвшөөрсөн.⁵ Өөрөөр хэлбэл хоёр орны хооронд байгуулагдсан найрамдалт харилцаа эрх тэгш үндсэн дээр байгуулагдсан байна.

Аюуширдар хааны дүү Төгстөмөр /1378-1388/ хаан суух үед монголчууд Хятадруу уулгалан довтолж байсан бөгөөд харин 1380 онд Мингийн цэрэг Монголд халдаж Хархорум хотыг галдаж их хэмжээний хүн ардыг олзолсон.

Төгстөмөр хаанаас хойш Монголын хаан ширээний төлөө тэмцэл хурцдаж байхуйд Мин улс монголчуудын дунд яс хаяж нэгийг нь нөгөөгийнх нь эсрэг тухирах бодлого явуулж байсан агаад Монголын нэгдсэн хүчирхэг улс байгуулагдааас аюул болно гэдгийг яс махандаа шингэтэл ойлгож байв. Чухамхүү энэ үеэс Монголыг "Баруун зүүнээр нь" хагаралдуулах бодлого явуулж эхэлсэн бөгөөд энэ нь хятадын гадаад бодлогодоо хэрэглэж ирсэн уламжлалт "и и чжи и" /зэрлэгүүдийг зэрлэгүүдээр захируулах/ хийгээд "цзи ми бу цзе" /жолоогоо сулруулахгүй хазсаарлан барих/ зэрэг аргууд байв. Ингээд Буняшир /1408-1413 онд/ хаан сууж байхад 1409 онд Мин улс Ойрадын Бахмуд "Шунынин ван" /Амгалан ван/, Тайванд "сян и ван" /Цэцэн ван/, Батула чинсанд "ань ле ван" /Энх түвшин ван/ цол хүртээж байсан нь⁶ тэдгээр Ойрадын язгууртнуудыг зээр татах бодлогын илрэл буюу. Төдөлгүй Ойрадын Бахму тайж Буняширийг хороож төрийн тамгыг булаан Хархорумыг эзлэн авч түүний хүү Дэлбэгийг /1413-1415/ хаан ширээнд суулгасан. Түүхэнд 1414 онд Ойрадын цэрэг Мингийн цэрэгтэй тулалдаж ялагдсан мэдээ байдаг.⁷ Адай /1422-1438/ хаан сууж байхуйд Мин улс нэг бол Ойрадыг,

Ж.Баясх

"XIV-XVII зууны Монголын галаад харилцаа"

нэг бол зүүн Монголыг өөртөө ашиглах бодлого явуулж нэгий нь нөгөөтэй нь сөргөлдүүлж дундаас ашиг олж нууцлэлчдийн найрамдаж худалдаа хийх гэсэн хүсэл эрмэлзлийг боогдуулж байв. Ойрадын Бахму өөд болмогц түүний хүү Тогоон баруун Монголын нөлөө бүхий ноён болж Тайван, Батболд нарттай байлдаж, тэднийг устган хүн ардыг нь эрхшээлдээ оруулаад, 1434 онд Зүүн Монголын Аругтай ноёнтонтой байлдан түүний хүчийг бүрмөсөн даран амийг нь хороов. Улмаар өөрийн ивээл дор байсан Тогтохбух Адай хааныг хороосноор 1438 онд хаан болгов. Ингээд Тогоон, Тогтохбухын дэргэд тайш /ерөнхий сайд/ болжээ. Тогоон, Тогтохбух нар Хятадад алба өргөх замаар худалдаа арилжаа хийхийн зэрэгцээ Хятад улс руу цэрэглэж түүнийг эрхэндээ оруулахыг оролдсоор байв. Тэд Бээжингээс хойшоо нутаглаж байсан Дзин, Фуюй, Тайнин харуулын монголчуудыг өөртөө татах бодлого явуулж эхэлжээ. Тогоон тайш Мин улстай байлдахаар бэлтгэж байгаад 1439 онд нас барсан. Тогоон тайш өөд болсны дараа түүний хүү Эсэн тайш болж Ойрадыг захирах болов.

Эсэн тайш Мин улстай хилийн худалдаа чөлөөтэй хийхийг шаардахаас гадна жил бүр Мин улсын хаанд амгалан айлтгах нэрийдлээр элч түшмэл зарахдаа тэдгээр хүмүүсийг дагалдуулан морь мал худалдуулахаар олон хүн явуулдаг байлаа. Ирсэн элч төлөөлөгчдийн тоогоор Мин улсын тал бэлэг сэлт өгдөг байсан тул элчийн тоо өссөөр 1000-3000 хүрэх болов.⁸ Чингээд 1440-1449 онд Эсэн тайшийн үед Монгол Хятад хоёр талаас жилдээ нэг нэг элч солилцож худалдаа хийдэг байсан.⁹ Гэхдээ уг нэг удаагийн элчийг дагаж олон хүн дагалдах болсны улмаас нэг хэсгий нь хилийн боомтноо үлдээж, цөөн хэсгий нь Бээжин-нэвтрүүлэх тооны хязгаар тавьсан. Мөн монголчуудын амьдрал ахуйд хэрэгтэй ширмэн тогоо, төмөр эдлэл өгөхгүй болсон хийгээд бараа болж дагалддаг бэлэг сэлт өгөлгүй буцааж байснаас улбаалан Эсэн тайшийг дайнд бэлтгэхэд хүргэв. Эсэн Хятад улс руу довтлохоосоо өмнө ар талаа бэхжүүлж эхлээд Хамийг буулган авч, улмаар Урианхайн гурван харуултай ураг төрлийн холбоо тогтоож авав. Үүний дараа 1449 онд Хятадын Мин улсын эсрэг цэрэг хөдөлгөсөн. Эсэнгээр удирдуулсан 20 мянган цэрэг Датун руу, Тогтохбухаар удирдуулсан цэрэг Ляодун руу, мөн тэргүүн сайд Алаг чинсан Сюаньфу руу тус тус довтолжээ.

Ж.Баясх

"XIV-XVII зууны Монголын галаад харилцаа"

Мөн оны 8-р сард Мин улсын эзэн хаан Инцзун 50 мянган цэрэг толгойлон утаж байлдахаар Датуныг чиглэн явжээ. Түүний цэрэг Датунд хүрэлцэн очиход Мингийн цэрэг Монголын цэрэгт хиаар цохигдсон байв. Инцзун Ойрадын цэрэгтэй халз тулахаас айн эмээж Бээжиндээ буцахаар шийджээ. 8-р сарын сүүлээр Бээжинд ухрах замдаа Сюаньфу хэмээх газарт дөнгөж ирсэн байхад Монголын цэрэг араас салалгүй мөрдөж мөн ирсэн байлаа. Ойрадын цэрэг Мин улсын Чжу Юн, Би Шоу нарын удирдсан дөрвөн түмэн цэргийг бүслэн авч хиагтал хяджээ. Инцзун хаан улдсэн цэргийнхээ хамт цаашид ухарсаар Туму хэмээх газарт /Хэбэй мужийн Хуйлай саний нутаг/ түр хуараглан бусан ба Эсэн тайшийн цэрэг тэд нарыг бүслэн авчээ.¹⁰ Тумугийн дэргэдэх тулалдаанд Мин улсын цэрэг ялагдаж эзэн хаан Инцзун Эсэнд олзлогдож дараа жилийн 8-р сар хүртэл монголчуудын дунд байж байгаад Мин улсад буцаагдсан юм. Ингээд 1450 оны 8-р сараас 1455 онд Эсэн тайш амь үрэгдэлт Монгол, Хятадын Мин улсын хооронд найрамдалт харилцаа тогтоож худалдаа арилжаа явагдаж байв.

Эсэн тайшаас хойш 1466 онд Батмөнх хаан ширээнд сууснаар Монгол улс дахин нэгдэх үйл явцад орсон. Батмөнх даан хаан 1488 онд Мин улсын Сюаньфунд хаанд элч илгээж "Их Юань улсын хаан" болсноо мэдэгдээд найрамдалт харилцаа тогтоон, худалдаа хийхийг хүсчээ. Эл саналыг Мин улс хүлээн авч зөвшөөрсөн бөгөөд Батмөнх хааны элч төлөөлөгчдийг жил бүр хүлээн авч Цагаан хэрэм орчмын газарт жилд гурван удаа адууны зах гаргаж худалдаа өргөн хийж байв. Урьд өмнө ширмэн тогоо хийгээд төмөр эдлэл зэргийг монголчуудад худалдахыг хориглож байсан нь үгүй болжээ. Иймд монголчууд дурдсан цагт морь, үхэр, ангийн үс, адууны дэл зэрэг мал аж ахуйн бүтээгдэхүүн авчирч, Хятадын худалдаачид торго дурдан, бөс даавуу, ширмэн тогоо зэрэг өргөн хэрэгцээний бараа болон хөдөө аж ахуйн бусад төрлийн бүтээгдэхүүн авчирч худалдаа наймаа хийдэг байжээ.¹¹ Батмөнх Даан хааны Мин улстай 1488 онд байгуулсан найрамдалт харилцаа 1500 он хүртэл үргэлжилсэн агаад хил орчмын газар нутагт хоёр талын хүн ард худалдаа эрчимтэй хийж байсан. Даан хаан бүрэн бус тооцоогоор 13 удаа элч төлөөлөгчөө Мин улсад илгээж байсан бөгөөд элч төлөөлөгчдийн тоо жилээс жилд нэмэгдэж байв. Тухайлбал, 1488 онд элч төлөөлөгчдийн тоо нь 1100 хүн байсан бол 1498 онд 6000 хүн болжээ.¹²

Түмэн засагт хаан, түүний эцэг Дарайсун хаан нас барсны дараа 1558 онд Монголын их хаан болсон. Харин Түмэдийн Алтан хан Түмэн хааны харьяаны хүн байсан бөгөөд Хятадтай харилцах явдалд Алтан ханы үүрэг их байжээ. Алтан хан Мин улстай найрамдалт харилцаа тогтоох худалдаа хийх сонирхолтой байсан авч тэр саналыг хүлээж авахгүй байсны улмаас хүч хэрэглэн өөрийн зорьсондоо хүрэх болжээ. Тэр бүр 1541 оноос 1551 он хүртэл Хятадын хил хязгаарыг туйвээж байсан агаад Мин улс 1551 оны хавраас түүний шаардлагыг хүлээн авч Датун зэрэг хил орчмын нутагт адууны зах нээв. Гэтэл эл байдал дахин эвдэргэлт тэр 1552 оны хавар дахин Датун руу дайрчээ. Алтан хан 1570 он хүртэл Хятадын газар нутаг руу довтолон дайрч байв. Мөн үед Түмэн засагт хаан ч мөн Мин улс руу хэдэнтээ довтолсон ажээ. Зөвхөн 1571 онд Алтан хан Датун, Чуулалт хаалга зэрэг газарт адууны зах гаргахыг Мин улс зөвшөөрчээ. Үүнээс хойш 20 жилийн турш Түмэн засагт хааныг өөд болтол хоёр улсын харилцаа үймээн, самуунгүй, элдэв боох хавчих явдалгүй хэвийн байсан ажээ.

Буян сэцэн хааны ач хүү Лигдэн 1604 онд Монгол улсын хаан ширээнд суужээ. Тэр бүх Монголыг нэгтгэн захирах тал дээр багагүй зүтгэсэн Чингисийн угсааныхныг үнэлж, харин Хятадын зүүн хойт хаан байхуйд Мин улс улам доройтож, харин Хятадын зүүн хойт нутагт Манж нар улам хүчирхэгжиж байсан үе юм. 1618 оны 4-р сард Манжийн Нүрхачи Яху, Идүцэн, Цэчэн зэрэг цайз боомтыг дайрч эзэлж авсаны дараагаар Мин улс хил хязгаараа хамгаалахад үлэмж санаа тавих болж Лигдэн хааныг хамсаатан холбоотноо болгох үүднээс түүнд найр тавьж Монголттой найрамдаж худалдаа хийн, тэр ч атугай Лигдэн хаанд жил бүр нэг мянган лан цагаан мөнгө барих болжээ.¹³ Лигдэн хаан адууны зах гаргуулж, хүссэн зүйлсээ элдэв хориг саадгүйгээр худалдан авдаг байлаа. Лигдэн хаан эхэн үедээ Хятадтай харилцах явдлыг чухалчлан үзэж манж нарын ойртох гэсэн сонирхлыг үл тоомсорлож байснаа 1619 онд Хятадыг өмгөөлж Төлин хэмээх газар байлдаж ялагдсанаас хойш Манжийг хөнгөнд үзэхээ больсон ажээ. Мөн тэр Мин улсаас хил хязгаарыг нь хамгаалсанд жил бүр их хэмжээний мөнгө нэхэх болж, улмаар 1628 онд Мин улс түүний нэхэмжилсэн 13000 лан цагаан мөнгө өгөөгүйд хорсож, Сюаньфу, Датун хоёр боомтод дайран орж бүснүүлсэн түүхтэй. Тухайн үед Мин улсын хувьд Манж нараас

түүнийг эмээж байсан учир хэл хязгаараа хамгаалахад Лигдэн хааны оруулсан зүтгэлтэйг үнэлэн шан харамжаа 81 мянган пан хүртэл нэмэгдүүлэхээ амалж байв.¹⁴

Дээр өгүүлсэнийг дүгнэхүйд тухайн үеийн Монголын гадаад харилцаа хязгаарлагдмал байсан бөгөөд гадаад улс төрийн бодлого Монгол-Хятадын хоёр талын харилцаанд дээр голлон төвлөрч байв. Монгол-Хятадын харилцаанд Монголын хаад (Аюуширдар, Эсэн тайш, Батмөнх) нэг үе Хятадын Мин улсыг эзлэн авч дахин ноёрхлоо тогтооход голлон анхаарч байсан бол хожим нь Түмэн засагт хаан, Алтан хан, Лигдэн хааны үед зөвхөн найрамдаж ашигтай худалдаа хийх сонирхол давамгайлж байв. Гэхдээ XIV-XVII зууны бүхий л үед монголчууд аль аль зорилгодоо хүрэхийн тулд хүч хэрэглэх явдлыг гол хэрэгслээ болгож байжээ. Харин Хятадын Мин улс монголчуудыг аль болох нэгдэлгүй тархай байлгах зорилгоор яс хаях, хооронд нь хагалах сонирхол давамгайлж монголчууд нэг үе нэгдэн довтолмолц найрамдаж түр зуур худалдаа хийх замаар амиа аргацааж сүл дорой хамгаалалтын шинж бүхий гадаад бодлого барьж байв. Ер нь өгүүлэн буй үед хоёр улс эрх тэгш харилцаатай байжээ хэмээн дүгнэж болно.

Номзүй:

1. Н.Ариунгуа "XIV-XVII зууны Монгол-Хятадын харилцаа" УБ., 1996, 9-р тал
2. Мөн тэнд, 10-р тал
3. Henry Setpurs. "The Mongols and Ming China: Customs and History". 1967, V, pp. 306-307
4. Ibid V, p. 240
5. "XIV-XIX зууны Монголын гадаад харилцаа", УБ., 1997, 18-р тал
6. Мөн тэнд, 26-р тал
7. Ж.Баясах, "Дорно дахины судлалын зарим асуудал", УБ., 1995, 155-р тал
8. Н.Ариунгуа, Дурдсан зохиол, 31-р тал
9. Ж.Баясах, Дурдсан зохиол, 156-р тал
10. "XIV-XIX зууны Монголын гадаад харилцаа", 37-р тал
11. Мөн тэнд, 40-р тал
12. "Мин Сюацзун шилу /Мин улсын Сюацзун хааны үнэн тэмдэглэл", Сюацзун хааны анхдугаар оны 9-р сарын харачин түүний өдөр, Сюацзун хааны 11-р оны 2-р сарын шарагчин могой өдрийн тэмдэглэл
13. "Мэнгу цзу тунши /Монгол үндэстний товч түүх", 2-р дэвтэр Бээжин, 1991, 612-р тал
14. Д.Покотилов, "История восточных монголов в период династии Мин /1368-1634", Санкт-Петербург, 1893, стр. 216

Ж.Баясах

"XIV-XVII зууны Монголын гадаад харилцаа"

Р.НИКСОН БА ХАТАД-АМЕРИКИЙН ХАРИЛЦААНЫ ШИНЭ ҮЕ

Доктор (Ph.D) Л.Бээгжав
ШУА, Олон Улс Судлалын Хүрээлэн

АНУ-ын 37 дахь ерөнхийлөгч Ричард Милкаус Никсон 1969 онд АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсоныхоо дараа юуны өмнө, түүхэнд мөрөө үлдээх, мөн ерөнхийлөгчөөр дахин сонгогдох үйл ажиллагаанд гол анхаарлаа хандуулсан юм.

1969 оны 1-р сарын 20-нд Р.Никсон ерөнхийлөгчийн албан тушаалд орох үедээ "Бид сөргөлдөөний үе шатны дараа гэрээ хэлэлцээрийн эрин үед орж байна." гэж хэлсэн юм. Р.Никсон гадаад бодлогын хувьд Хятадтай найрсаг харилцаа, тогтоохыг нэн түрүүнд анхаарсан юм. Иймээс ч улс төрийн тавцанд гарсныхаа дараа анхны захирамж нь 1969 оны 2-р сарын 1-нд "Хятадтай холбоо тогтоох бололцоог дахин шинээр эрж хайх тухай" байв.

Хятад-Америкийн харилцааны түүх нь эздэрээтэй бөгөөд олон жилийн турш сөргөлдөөнтэй явж ирсэн юм. Хятадын удирдагчид гадаад улс төрийн стратегидаа АНУ, Япон болон Өрнөдийн орнуудыг чухал ач холбогдолтойд ямагт үздэг байв. Бүр БНХАУ байгуулагдахаас өмнө 1944 оны 8-р сарын 23-нд Мао Зэдун Яньбанд АНУ-ын элчин сайдын яамны төлөөлөгч Жон Сервис-тэй ярилцахдаа: "Хятад-Америкийн эрх ашиг хоорондоо холбоотой адил төстэй байна. Энэ хоёр улс улс төрийн талаар ч, эдийн засгийн талаар ч таарч тохирч байна. Бид хамт ажиллаж чадна. Тэгэх ч ёстой" гэж мэдэгдэж байв. Гэвч тодорхой нөхцөл байдлын улмаас Хятад-АНУ-ын харилцаа 70-аад оны эхэн хүртэл сөргөлдөөнтэй хэвээр байв. Р.Никсон БНХАУ-тай харилцах АНУ-ын шинэ бодлогыг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Энэ чиглэлээр нэлээд олон шийдвэрийг Р.Никсон өөрөө санаачлан гаргаж байлаа. 1970 оны 10-р сард Р.Никсон Хятад-Америкийн харилцааг мухардмал байдлаас гаргах санаагаа илэрхийлж "Хэрэв би үхэхээсээ өмнө ямар нэгэн хэрэг үйлс хийх хэрэгтэй гэвэл энэ нь хятадад очих явдал юм. Би очиж чадахгүй байлаа ч миний үр хүүхдүүд очих хэрэгтэй" гэж хэлж байлаа. Тэрээр НҮБ-ын 25 жилийн ойн арга хэмжээнд оролцохоор очсон Пакистаны

Л.Бээгжав

"Р.Никсон ба Хятад-Америкийн харилцааны шинэ үе"